

ХОРИХ ЯЛААС ХУГАЦААНААС ӨМНӨ СУЛЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ /ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА/



Б. ГАЛБАДРАХ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн
Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын тэнхимийн дэд
профессор, доктор /Ph.D/, ахмад

Товч агуулга: Илтгэлд гадаадын зарим орны хорих ялаас хугацаанаас өмнө суллах зохицуулалтын онцлогийг авч үзсэн.

Abstract: The article is devoted to the analysis of features of foreign countries in the application of early conditional release of imprisonment.

Түлхүүр үг: Хорих ял, гадаадын зарим орны эрүүгийн хууль тогтоомж, туршилтын хугацаа, хорих ялаас хугацаанаас өмнө сууллах.

Keywords: imprisonment, criminal legislation of foreign countries, early conditional release of imprisonment.

Жил бүр хорих байгууллагаас хууль заасан тодорхой үндэслэлээр 200 гаруй хүн суллагдаж байна. Эдгээрийн дийлэнх хувийг хугацаанаас өмнө суллах үндэслэлээр суллагдах явдал эзэлж байна. Хугацаанаас өмнө суллах нь “хорих байгууллагын оршин суугчид” гэж нэрлэж болох хүний тоог бууруулах, тэдний, нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх, цаашид нийгэмд дасан зохицоход чухал ач холбогдолтой юм.

Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах институтийг дэлхийн дийлэнх орнууд эрүүгийн хуульдаа хуульчилсан байдаг бөгөөд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн эрх зүйн институтийн нэг юм. Хорих ялаас хугацааны өмнө суллах институтийг анх 1855 онд Францын эрүүгийн хуульд хуульчилсан байдаг байна.

Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах институт нь энэрэнгүй ёсны зарчимд үндэслэсэн байдаг бөгөөд хугацаанаас өмнө ялын зорилго хангагдсан тохиолдолд ялыг цаашид эдлүүлэх шаардлагагүй гэсэн учиртай юм. Үүнээс гадна хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах явдал нь хорих байгууллагад дэг журам сахиулах болон хоригдлыг засарч хүмүүжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг юм.

Нэгдсэн Үндэстний байгууллагаас баталсан олон улсын стандартууд хоригдлыг суллах явдалд ихээхэн анхаарал хандуулдаг. Тухайлбал НҮБ-ын Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрмийн /1955/ шинэчилсэн хувилбар болох Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм /Манделлын дүрэм 2015/-д “...хоригдлыг суллахын өмнө түүнийг тодорхой шат дараалалтайгаар нийгэмд эргэн нэгтгэх арга хэмжээг хэрэгжүүлэх” гэж заасан байдаг. Энэ зорилгын хүрээнд хоригдол бүрийн хувь хүний онцлогийг харгалзан үзэх, суллагдсан болон суллагдах дөхсөн хоригдлуудад тусгай дэглэм, нөхцөлийг тогтоох, суллагдсаны дараа хяналтад байх туршилтын хугацааг тогтоох бөгөөд хяналтыг цагдаагийн байгууллага тавихгүй бөгөөд нийгмийн халамжийн үйлчилгээ, туслалцаа үзүүлэх хэрэгтэй гэж онцлон заасан байна¹. Манделлын дүрэмд заасан тус хэм хэмжээний гол агуулга нь пробацийн албаны хяналт бөгөөд үүний хүрээнд хорих байгууллагаас суллагдсан, нийгэмд эргэн нэгдэх оролдлого хийгдэж буй этгээдэд нийгмийн халамжийн үйлчилгээ, сэтгэл зүйн болон бусад туслалцааг үзүүлэх юм.

Хорих ялаас хугацаанаас өмнө суллах институтийг хэрэглэхэд хоёр үндэслэл байх нь чухал юм:

1. Материаллаг (ялын зорилго хангагдсан).
2. Ялын тодорхой хугацааг эдэлсэн.

Дийлэнх гадаадын орнуудын хууль тогтоомж нь XIX-XX зуунд үүссэн эрүүгийн “школ” гэж нэрлэгдэх үзэл бодлын нөлөөнд хөгжиж, хувьсан өөрчлөгдсөн байдаг. Үүний үр дүнд засан хүмүүжүүлэх байгууллага, насанд хүрээгүй хоригдлуудыг ял эдлүүлэх тусгай байгууллагууд байгуулагдаж, эрүүдэн шүүх хэлбэрийн ялын төрлөөс татгалзаж, зарим орнуудад цаазын ялаас бүрэн татгалзан, эрүүгийн хуулиасаа хасч, хорих ялаас хугацаанаас өмнө суллах явдлыг түлхүү хэрэглэж эхэлсэн байна. Энэ явдал нь ч шүүх илүү энэрэнгүй ялын төрлийг сонгож оногдуулах боломжийг ч олгосон. Энэхүү энэрэнгүй байдал нь ял эдлэхээс хугацааны өмнө суллахаар илэрдэг байна.

Гадаадын орнуудад хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах нийтлэг хэлбэр нь хяналт дор байлгаж, хяналт тогтоож суллах юм. Энэхүү системийн гол мөн чанар нь хоригдлыг ялаас хугацааны өмнө суллаж тэдний эрх чөлөөтэй байх хугацаанд хяналт тогтоох явдал юм. Баруун болон Зүүн Европын дийлэнх орнуудад хоригдлуудад ялынхаа тодорхой

¹ Манделлын дүрэм. 87-р зүйл.

хугацааг эдэлсний дараагаар хяналт тогтоож суллагдах хүсэлт гаргахыг зөвшөөрдөг байна².

Эдгээр улсуудын нийтлэг тал нь хугацааны өмнө сулагдсан этгээдүүдэд хяналт тавих болон бүх шатанд хяналт тавьж байгаа алба хаагчдад өндөр шаардлага тавих механизмтай явдал юм. Бүх шат гэдэгт хугацааны өмнө суллах асуудлыг хэлэлцэх, хяналт болон сулагдсаны дараа үзүүлэх тусламжийг ойлгож болно.

Канад болон Их Британид богино хугацааны хорих ял эдэлж байгаа хоригдлуудад хугацааны өмнө суллах, хяналт тавих арга хэмжээг хэрэглэдэггүй бөгөөд үүний оронд ялынхаа тодорхой хугацааг эдэлсний дараа шууд сулладаг байна. Удаан хугацааны ял оногдуулсан тохиолдолд тухайн хоригдол хугацааны өмнө суллах бүх шат дарааллаар явдаг. Их Британид зөвхөн дөрвөн жил буюу түүнээс дээш хугацаагаар хорих ял оногдуулсан этгээдийг ял эдлэхээс хугацааны өмнө суллах зохицуулалттай байдаг байна. Үүнээс гадна бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол ялын 9-12 жилийг биеэр эдэлсэн тохиолдолд хугацааны өмнө суллагдах болдог байна³. Хяналтыг биеэр эдлээгүй, ялын үлдсэн хугацаанд пробацийн албаны алба хаагч тавих зохицуулалттай.

Их Британийн чухал онцлогоос дурдвал 1997 оны “Гэмт хэрэгт оногдуулах ялын тухай хууль” нь ял эдлэхээс хугацааны өмнө суллах институтэд зарчмын гэж нэрлэж болохоор өөрчлөлт оруулсан байдаг. Тухайлбал, тус хуулийн 10 дугаар зүйлд дотоод хэргийн яамны сайд хоригдлыг гэр бүлийн тодорхой байдлаас хамааран суллах нөхцөл байдал үүссэн гэж үзсэн тохиолдолд хэзээ ч хамаагүй суллах эрхтэй гэж хуульчилсан байна.

Үүнээс гадна тус хуулийн дагуу дотоод хэргийн яамны сайдын зөвшөөрлөөр бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлуудыг ч хугацаанаас өмнө суллах боломжтой. Гэхдээ энэ зохицуулалт нь зөвхөн 18 хүртэлх насны хоригдол, тэдний үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах хорих ялын хугацааг хуульд тодорхой заагаагүй, шүүхийн тогтоолд тодорхой ялынхаа хугацааг эдэлсний дараа суллагдах боломжтой гэж заасан тохиолдолд л хамаатай гэдгийг онцлох зөв юм. Эдгээр этгээдүүдэд мөн гэр бүлийн онцгой нөхцөл үүссэн тохиолдолд хугацааны өмнө суллах

² Плюскин А.М. Организационно-правовые вопросы условно-досрочного освобождения осужденных к лишению свободы: дис ...канд. юрид. наук. – М., 2005, 52 дахь тал.

³ Полянский Н.Н. Уголовное право и уголовный суд Англии. М., 1969. 102 дахь тал.

зохицуулалтыг ч хэрэглэж болдог. Энэ нөхцөлөөр суллагдсан тохиолдолд заавал биелүүлэх тодорхой нөхцөлүүдтэй байдаг. Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг сулласан шийдвэрийг дотоод хэргийн яамны сайд цуцлах, хүчингүй болгох эрхтэй байдаг бөгөөд тухайн хоригдлыг ялын үлдсэн хугацааг эдлүүлэхээр хорих байгууллагаруу буцаадаг байна.

Их Британид ял эдлэхээс хугацааны өмнө суллах ажиллагаанд “Хугацааны өмнө суллах чиг үүрэг бүхий зөвлөл” гол үүргийг гүйцэтгэдэг. 1991 оны Эрүүгийн хуулийн дагуу энэхүү зөвлөлийн бүрэлдэхүүнд зөвлөлийн тэргүүн буюу шүүгч мөн 3 гишүүн багтдаг. Хэлэлцэж байгаа хэргийн онцлогоос хамаарч Зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орж болдог ба дотоод хэргийн яамны сайдтай зөвшилцдөг байна.

Терроризм, хүн алах, цагдаагийн ажилтан, хорих байгууллагын ажилтны амь, биед хүнд гэмтэл учруулах, насанд хүрээгүй хүнийг хүчирхийлэхийг завдах, хүчиндэх, өмнөх ялаас хугацааны өмнө суллагдан хяналтад байх хугацаандаа санаандгүй хүн алах гэмт хэрэг үйлдэж бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ялаас хугацааны өмнө суллах асуудлыг хэлэлцэх тохиолдолд Зөвлөлийг Эзэн хааны шүүхийн шүүгч даргалдаг зохицуулалттай.

Бусад бүх тохиолдолд Зөвлөлийг орон нутгийн эрүүгийн хэргийн шүүхийн шүүгч даргалдаг. Дүрмийн дагуу тус Зөвлөлийн нэг гишүүнээр сэтгэл зүйчийг томилдог ба зарим тохиолдолд сэтгэл зүйл эсхүл пробацийн албаны офицерыг ажиллуулдаг байна. Зөвлөлийн өөр нэг гишүүнээр криминологич, сэтгэл зүйч эсхүл пробацийн албаны офицерыг ажиллуулдаг.

Франц Улсад хорих ял шийтгүүлсэн этгээд засрал хүмүүжлээ харуулсан, учруулсан хохирлоо барагдуулсан, эргэн нийгэмд нэгтгэх хангалттай үндэслэл байгаа тохиолдолд хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах зохицуулалттай. Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлуудын хувьд 15 жилийн хорих ялыг биеэр эдэлсний дараагаар хугацааны өмнө суллах асуудлыг хэлэлцдэг байна (Франц Улсын Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 729-р зүйл)⁴.

Франц Улсад хугацааны өмнө суллах эрх бүхий хүн нь хууль зүйн сайд байдаг бөгөөд хоригдлыг хугацааны өмнө суллах тогтоолыг түүнд хүргүүлж шийдвэрийг гаргуулдаг байна. Тогтоолд хоригдлын ял эдэлж

⁴ Плюскин А.М. Организационно-правовые вопросы условно-досрочного освобождения осужденных к лишению свободы: дис ...канд. юрид. наук. – М., 2005, 55 дахь тал.

байгаа хорих байгууллагын дарга, ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шүүгч, прокурор, хоригдол суллагдсаны дараа оршин суух засаг захиргааны нэгжийн тэргүүлэгч, хорих байгууллага байршиж байгаа захиргааны нэгжийн тэргүүлэгчийн саналыг тусгадаг байна (Франц Улсын Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 730-р зүйл).

Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол хугацааны өмнө суллагдсан тохиолдолд 5-аас 10 жил хүртэл хяналт тогтоодог онцлогтой.

Америкийн Нэгдсэн Улсад хугацааны өмнө суллах асуудлыг Мужийн хугацааны өмнө суллах ажиллагаа хариуцсан зөвлөл шийдвэрлэдэг. Үйлдсэн гэмт хэргийн хөнгөн, хүндээс хамаарч хорих ялын 6/7, 2/3 эсхүл 1/2 эдэлсний дараа ялаас хугацааны өмнө суллагдах боломж үүсдэг. Нью-Йорк мужийн эрүүгийн хуулийн дагуу I зэргийн хүнд, хүн алах гэмт хэрэг үйлдсэн хоригдлыг хугацаанаас өмнө суллахыг хориглодог байна⁵.

Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлууд ч хугацааны өмнө суллагдах эрхтэй байдаг бөгөөд үйлдсэн гэмт хэрэгт оногдуулж болох ялын хугацааг эдэлсний дараа суллагдах боломжтой юм.

Үүнээс гадна АНУ-д бүх насаар хорих ялыг суллагдах боломжгүйгээр оногдуулж болдгийг дурдах нь зүйтэй. Мөн бүх насаар хорих ял шийтгүүлсэн этгээд ялын хугацааныхаа 10 жилийг эдэлсэн тохиолдолд хугацааны өмнө суллаж болдог⁶. Үүнээс гадна хорих ял эдлэхээс хугацаанаас өмнө суллахад хоригдлын цаашид биеэ авч явах чиг хандлагад ач холбогдол өгдөг. АНУ-ын Эрүүгийн хуулийн дагуу хугацаанаас өмнө суллагдаж байгаа хоригдол суллагдахын өмнө хорих байгууллагаас суллагдсаны дараа оршин суух газар, эрхлэх ажлын талаар тодорхой мэдээллийг тусгасан төлөвлөгөөг бэлдэх ёстой.

Австри Улсад бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ялынхаа 15 жилийг биеэр эдэлсэн тохиолдолд суллаж болдог.

Австри Улсын Эрүүгийн хуульд зааснаар хугацааны өмнө суллагдсан хоригдлын биеэр эдлээгүй хугацаанаас хамаарч суллагдсан этгээдэд 1-ээс 5 жил хугацаанд туршилтын хугацааг тогтоодог. Бүх насаар хорих ял шийтгүүлсэн этгээд болон сэтгэцийн эмгэгтэй хоригдол, рецидив гэмт хэрэг үйлдсэн хоригдол хугацааны өмнө суллагдсан тохиолдолд 10 жилийн хугацаатай туршилтын хугацааг тогтоодог байна.

⁵ Уголовный кодекс штата Нью-Йорк // Уголовное законодательство зарубежных стран: сборник законодательных материалов / под ред. И.Д. Козочкина. М., 1999. 53 дахь тал.

⁶ Преступление и наказание в Англии, США, Франции, ФРГ, Японии. М., 1991. 243 дахь тал.

Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллахыг дараах тохиолдолд хэрэглэж болохгүйг дурдах зөв юм:

- Хоригдол эрх чөлөөтэй болсны дараа гэмт хэрэг үйлдэх боломжтой гэх үндэслэл байгаа тохиолдолд;

- Бусад этгээд гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор ялын үлдсэн хугацааг биеэр эдлүүлэх шаардлагатай тохиолдолд.

Австри Улсад ял эдлэхээс хугацааны өмнө суллах шийдвэрийг шүүгч гаргадаг бөгөөд шүүгч хоригдолд хуулийг дагаж мөрдөх, ертөнцийг эерэгээр харахад туслалцаа үзүүлэх туслахыг томилдог байна. Туслах нь төрийн бус байгууллагын ажилтан эсхүл албан ёсны зөвшөөрөлтэй шашны байгууллагын ажилтан байж болдог.

Дани, Норвеги, Швед улсуудад ч мөн хяналтыг суллагдсан этгээдийн оршин сууж байгаа газрын орон нутгийн нийгмийн ажил эрхэлсэн сайн дурын ажилтан тавьдаг байна. Эдгээр улсуудад мэргэжлийн пробацийн алба үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд энэ байгууллага нь суллагдсан хоригдолд хяналт тавих, нийгэмд дасан зохицоход туслалцаа үзүүлдэг сайн дурын иргэдтэй хамтран ажилладаг.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хуулийн 57 дугаар зүйлд заасны дагуу хорих ялаас хугацааны өмнө суллах зохицуулалтыг тусгасан байдаг байна. Мөн бүх насаар хорих ял эдэлж байгаа хоригдлыг 15 жил ял эдэлсний дараа 5 жилийн туршилтын хугацаатай суллаж болдог байна. 1977 онд Германы Үндсэн хуулийн шүүх бүх насаар хорих ялыг тодорхой хугацаа нь туршилтын нөхцөлтэй байх, эдгээр хоригдлуудыг дахин нийгэмшүүлэх, засан хүмүүжүүлэх нь зохистой гэж үзсэн байна. Мөн 2-оос 5 жил хүртэл хугацаагаар туршилтын хугацааг тогтоодог. Тус улсын нэг онцлог бол хоригдлыг хугацаанаас өмнө суллахад тухайн хоригдлын өөрийн зөвшөөрөл шаардлагатай байдаг.

Тус Улсын эрүүгийн хуулийн дагуу шүүх суллагдсан хоригдлын туршилтын хугацаанд тусгайлсан туслахыг томилдог байна. Туслахын гол чиг үүрэг нь суллагдсан этгээдийн туршилтын хугацаанд түүнд халамжийн үйлчилгээ үзүүлэх, зан байдал, биеэ авч явах байдалд хяналт тавих бөгөөд мөн шүүхээс түүнд оногдуулсан үүргийг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавьдаг.

Эдийн засаг, хууль эрх зүйн салбарын хувьд хурдацтай хөгжиж буй Бүгд Найрамдах Хятад Ард Улсыг дурдахгүй өнгөрч болохгүй юм. БНХАУ-ын Эрүүгийн хууль 81-р зүйлийн дагуу хорих ял эдэлж байгаа

хоригдол ялынхаа 1/2 эдэлснээр хугацааны өмнө суллагдах боломжтой болдог бөгөөд энэ зохицуулалт нь зөвхөн 10 хүртэл жилийн ял шийтгүүлсэн хоригдлуудад хамааралтай юм. Харин давтан гэмт хэрэг үйлдсэн, 10-аас дээш жил болон бүх насаар хорих ял шийтгүүлсэн этгээдүүдийг хугацааны өмнө суллаж болохгүй гэсэн зохицуулалттай байдаг байна⁷. Хугацааны өмнө суллах саналыг Ардын дээд шүүх хянан үзэж хорих байгууллагын захиргаанд тогтоолыг хүргүүлдэг.

Мөн тус Улсын нэг онцлог бол санал ирснийг Ардын шүүх тав хоногийн дотор нийтэд мэдээлэх үүрэгтэй явдал юм. Ардын шүүх нь гэмт хэрэгтний үндсэн мэдээлэл, үйлдсэн гэмт хэрэг болон оногдуулсан ял, урьд өмнө нь үйлдэж байсан гэмт хэрэг, ял эдлүүлэх байгууллагын санал, хугацааны өмнө суллах үндэслэлийг мэдээллэдэг. Мэдээлэл нь тав хоногийн дотор хугацаатай олон нийтийн саналыг авах, холбоо барих боломжийг зааж нийтлэгддэг. Шаардлагатай тохиолдолд Ардын шүүх нь хоригдлын гэмшсэн, байгуулсан гавьяаг нотлох эсхүл ялыг хөнгөрүүлэхийн эсрэг байр суурьтай байгаа гэрч, шинжээч, орчуулагч болон бусад этгээдийг дуудаж тайлбар авдаг байна⁸.

ОХУ-ын Эрүүгийн хуульд заасны дагуу ялтан өөрийн засрал, хүмүүжлээ харуулсан, учруулсан хохирлоо бүрэн эсхүл хэсэгчлэн барагдуулсан тохиолдолд хорих ялаас хугацаанаас суллаж болдог. Тухайбал, хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэж ялын 1/3 эдэлсэн, хүнд гэмт хэрэг үйлдсэн бол ялын 1/2, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн бол 2/3, насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, борлуулах гэмт хэрэг үйлдсэн бол 3/4 эдэлсэн тохиолдолд ялаас хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоодог байна.

Мөн хугацаагүй хорих ял буюу бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг 25 жил ял эдэлсний дараагаар хугацаанаас өмнө суллах асуудлыг хэлэлцэж болдог бна.

Үүнээс гадна ОХУ-ын Эрүүгийн хуулийн 56 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу терроризм, хүн барьцаалах зэрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд 30 хүртэл жилийн хорих ял, эдгээр гэмт хэргийг үйлдэж хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулсан тохиолдолд 35 хүртэл жилийн

⁷ БНХАУ-ын Эрүүгийн хууль http://cnlegal.ru/criminal_law/china_supreme_court_parole_procedure

⁸ БНХАУ-ын Эрүүгийн хууль http://cnlegal.ru/criminal_law/china_supreme_court_parole_procedure

хорих ял оногдуулдаг байна. Энэ тохиолдолд хорих ялын 3/4 хугацааг эдэлсэний дараагаар хугацаанаас өмнө суллах асуудлыг хэлэлцэж болдог байна. Гэтэл ОХУ-д бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлуудын дунд 25 жил ял эдэлсэн хоригдлууд байгаа бөгөөд эдгээр хоригдлууд хэд хэдэн шийтгэх тогтоолоор яллагдсан хоригдлуудаас өмнө, тэр дундаа хугацаатай хорих ял эдэлж байгаа хоригдлуудаас өмнө суллагдах боломжтой байгаа нь эрх зүйн коллиз буюу зөрчилдөөнийг үүсгэж байна⁹. Иймд энэхүү зөрчилдөөн нь цаашид шийдвэрлэх чухал асуудлын нэг юм.

Объектив талаас хоригдлыг засарч хүмүүжсэнийг үнэлэхэд хэцүү байдаг учир зарим орны эрүүгийн хууль тогтоомжид хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллахад ял эдлэх хугацаанд биеэ зөв авч явсан зөрчил гаргаагүй байдалд анхаарал хандуулдаг. Жишээ нь Беларусь Улсад хоригдол ял эдлэх хугацаандаа зөрчил гаргаагүй, сахилга баттай байсан тохиолдолд хугацаанаас өмнө суллаж болно гэж заасан байдаг¹⁰. Энэхүү заалтаас хорих ял эдлэхээс хугацаанаас өмнө суллах нь урамшууллын нэг хэлбэр гэдэг нь тодорхой харагдаж байна.

Гадаадын зарим орнуудын ял эдлэхээс хугацааны өмнө суллах зохицуулалтыг судлан үзэхэд дараах дүгнэлтэд хүрч байна:

1. Ял эдлэхээс хугацааны өмнө суллах ажиллагаанд хангалттай тооны субъектүүд оролцдог бөгөөд суллах шийдвэрийг өөр өөр байгууллагууд гаргадаг. Жишээ нь АНУ, Их Британи болон Канад улсуудад ял эдлэхээс хугацааны өмнө суллах комисс, Франц Улсад хууль зүйн сайдын дэргэдэх зөвлөх хороо, Холбооны Бүгд Найрамдах Герман болон Австри улсуудад шүүх шийдвэр гаргадаг байна.

2. Биеэр ял эдлэх хугацаа харилцан адилгүй байдаг.

3. Суллагдсаны дараа туршилтын хугацаа байдаг бөгөөд мэргэжлийн пробацийн алба болон сайн дурын ажилтнууд хяналт тавьж нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлдэг байна.

⁹ Батболд Галбадрах Обеспечение прав осужденных, отбывающих наказание в виде лишения свободы, в Российской Федерации и Монголии: дис ...канд. юрид. наук. – Омск, 2018, 148 дахь тал.

¹⁰ Уголовный кодекс Республики Беларусь // Законодательство Республики Беларусь. М., 2006. 5 дахь тал.